МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛЫН ЯАМ

О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД

I

Улаанбаатар

2022

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛЫН ЯАМ

О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН

ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД

I

Эрхэлсэн:

Доктор Э.Пүрэвжав

Монгол бичгээс хөрвүүлж галигласан:

Э.Оюунтунгалаг, М.Очирцэнд

Тайлбар зүүлт хийсэн: Э.Пүрэвжав, Б.Лхагважав

ISBN: 978-9919-9852-7-1

Оршил

Тус зохиолыг 1914 онд анх хэвлүүлжээ. Монголын уламжлалт хэл зүйн бичгүүдэд дурдаж ирсэн монгол бичгийн зөв бичих дүрмийг товчлон, анхлан сурах хийгээд сургахад зайлшгүй хэрэгтэйг нь түүвэрлэн бичжээ. Тус номын төгсгөлийн үгэнд "*... нарийн учир маш олон боловч дэлгэрүүлэн бичихүйд мунхаг оюунд багтааж чадсангүй бөгөөд "Огторгуйн маани" хэмээх сударт тодорхой номлосны тулд түүнээс үзэж мэдэгдэхүй хэмээн мэргэдийн сууринаа эрхшээсэн Алшаагийн молом равжамба Агваандандарын зохиосон "Хэлний чимэг" хэмээх номлолыг гол эш болгож, мөнхүү түүнд хааяа зарим нэгэн бүдүүлгийг нь бусад мэргэдийн илэрхий зохиолоос түүж бага сагаар нөхөж бүдүүвчлэн бичсэн*" хэмээн бичсэнээс нь үзэхэд Агваандандарын "Хэлний чимэг" зохиолыг голлон барьж, тус номд ороогүй, эсвэл утга нь бүрхэг зарим хэсгийг бусад ном судраас шүүж бичжээ. Мөн тус төгсгөлийн үгэнд "Огторгуйн маани"-ийн нэрийг цухас дурдсан хэдий ч гол болгон ашиглаагүй бололтой.

Зохиолын эхэнд Сажа бандида Гунгаажалцан, Чойжи-Одсэр нар монгол бичгийн цагаан толгойг 44, 100, 123 зүйл үсгээр зохиосон хэмээн бичсэн байх бөгөөд энэ зохиолоо бичиж асан цаг хугацаа нь "Урт өдрийн улиг үгний бичиг" хэмээх зохиолоо бичихээс даруй 11 жилийн өмнөх үе болох тул энэ үед тус домгийн баримтад эргэлзэж эхлээгүй байсан нь тодорхой харагдаж байна.

Зохиогч цааш нь бичихдээ "*үүнээс гадна олон богд мэргэдийн зохиосон монгол үсэг олон боловч, манай Монголын бичиж журам болсон хэдэн үсгийг товчлон гаргаваас*" хэмээн Чойжи-Одсэрийн үеэс уламжилж ирсэн 123 үсэгт багтаагүй ч хожмын зохиол бүтээлд нэмэгдэж, нийт монголчуудын дунд бичиж хэвшсэн "лха", гадаад үгийн "з", "ц" зэрэг үсгийн хэлбэр, онцлогийн тухай тайлбарлан бичжээ. Жишээлбэл: "ла, хөндий хэмээх х хоёр үсгийг давхарлан бичвээс "лха" хэмээмүй" гэхчлэн бичжээ.

Өмнөх үеийн уламжлалт хэл зүйн бичгүүдэд бичсэнчлэн дэвсгэр үсэг, тэдгээрийн үгийн дунд, адагт хэрхэн дэвсгэрлэх дүрмийг тайлбарлан бичжээ. "Сайхан", "далай" гэх мэт үгсийг өнөөгийн монгол бичгийн сургалтад хос эгшиг, "хууль", "эргүү" гэх мэт үгсийг эдүгээ урт эгшиг хэмээн зааж буй. Жамьян гүн эдгээрийг өмнөх хэл зүйн бичгүүдийн уламжлалыг даган "дэвсгэр үсэг"-ийн тоонд оруулжээ.

Уламжлалт хэл зүйн бичгүүдэд хос эгшгийн араас залгасан дэвсгэр үсгийг "давхар дэвсгэр" хэмээн томьёолсон байдаг бөгөөд энэ тухай "*бас "йа" дэвсгэрийн доор "н, г, д, м, л, р, с" энэ долоон үсгийг дэвсэж давхар дэвсгэр хэмээдэг буй. Аль буй хэмээвээс" айн, айг, айд, айм, айл, айр, айс" энэ мэт болой. "Айнг, айв" хэмээн бичиж болохоор номлосныг үзсэнгүй тул эс бичвэй*" хэмээн бичжээ. Уламжлалт хэл зүйн бичгүүдэд давхар дэвсгэрт "нг, в" хоёрыг оруулж, эдгээрт жишээ бичсэн байдаг хэдий ч зохиогч үүнийг хэл зүйн бичгээс бусад ном

судраас олж үзээгүй бололтой. Үүнээс бид Жамьян гүн өмнөх үеийн зохиол бүтээл, хэл зүйн бичгүүдэд нэгэн янзаар хуулагдаж ирсэн зарчим, дүрмийг зүйлүүдийг тэр хэвээр авч хуулж байхыг боддоггүй, харин ч өөрөө судлан шинжилж, бусад ном судартай тулган нягталж бичдэг байсныг харж болно.

Тийн ялгалын нөхцөл, сул үгийг хэрхэн зөв дагуулах тухайд хатуу зөөлөн дэвсгэр, хүйс, илэрхийлэх утга зэргээр нь ялган, нэгэн ангид багтах нөхцөл, сул үгийг багцлан нэг дор бичжээ. Жишээлбэл: "*...ба, га, ра, са, да энэ таван дэвсгэрийн доор болбоос "-тур, -таган, -тэгэн" гурвыг бичээд, дэвсгэр үсэгт залгаж бичих "-ч"-г мөн үүнд бичмүй. "-дур, -даган, -дэгэн", дэвсгэр үсэгт залгаж бичих "-ж" энэ дөрвийг мөн ба, га, ра, са, да таван дэвсгэрээс бусад зургаан дэвсгэр ба дэвсгэргүй үсэг бүгдийн доор бичмүй*" хэмээн дэвсгэр үсгийн дүрмийг, "*-нугуд, -лугаа, -даган, -таган, -ану энэ тавыг цөм эр үсгийн доор бичмүй. -нүгүд, -лүгээ, -дэгэн, -тэгэн, -инү энэ тавыг цөм эм ба эрс үсгийн доор бичмүй*" хэмээн хүйсээр ялган, "*-уу (-үү) үүнийг мөн үү? бус уу? хэмээх зэрэг асуух үгсэд хэрэглэмүй*" хэмээн илэрхийлэх утгын талаас нь ангилан бичжээ. Энэхүү арга нь өнөөгийн монгол бичгийн сургалтын аргад ч хэрэглэгдсээр байгаа хамгийн сайн, шалгарсан, сургахад хялбар арга хэвээр байгаа юм.

Түүнчлэн эгшиг үсгүүд үгийн эхэнд титэмтэй, үгийн дунд, адагт титэмгүй ордог, "ө, ү" үсгийн шилбийг ч үгийг дунд адагт бичдэггүй тухай тодорхой жишээ татан тайлбарлажээ. Мөн "гүйцэд, сүйтгэх" гэх мэт "үй"-ийн хос эгшгийг бичихдээ нэг шилбийг нь хурааж, хоёр шилбэтэй бичдэг зэрэг монгол бичгийн зөв бичих дүрмийг тайлбарлан бичжээ. Тогтсон дүрмээс зөрж бичдэг "хив, хир, агшин" гэх мэт уламжлалт бичлэгтэй үгсийн бичлэгийг засалгүй уул хэвээр бичиж байх нь зүйтэй хэмээн бичсэн бөгөөд энэ мэт үгсийг эдүгээ ч тэр өвөрмөц хэлбэрээр нь бичсээр буй.

МОНГОЛ ҮСГИЙН АЙМАГ. АНХАН СУРАХ ХӨВГҮҮДИЙН ОЮУНЫ АМЫГ НЭЭХ ТОДОРХОЙ ТОЛЬ ХЭМЭЭГДЭХ ОРШВОЙ

Лам Манзушир хийгээд Эгшигт охин тэнгэрт бишрэн сөгдөж мөргөмүй. Монгол үсгийн ёсон хэмээвээс Юань улсын анхны хаан Чингис богд тэр бээр Сажийн банчин Содномцимү[1] хэмээх лам лугаа найран зохицож лам барин шашны эх олсны учирт түүний дөрөвдүгээр үеийн хаан Гүндэн[2] Амдау[3] төвөдийн зүүн хойно ойр Шар талын Лианжу хотод суухуйн үест Сажа бандида Гунгаажалцан хэмээх ламыг залж лам барьснаар лам тэр бээр монголчуудад үсэг үгүй тул ямар дүрэмтэй үсэг болгохыг түгдэм барьж хоноод өглөө эрт бэлэг[4] шинжилбээс нэгэн эхнэр хүн хэдрэг модон барьж ирээд мөргөснөөр бэлэглэн[5] үсгийн дүрэм болгож *а, э, и, на, нэ, ни, ба, бэ, би, ха, хэ, хи, ма, мэ, ми, ла, лэ, ли, ра, рэ, ри, са, сэ, си, да, дэ, ди, та, тэ, ти, жа, жэ, жи, ча, чэ, чи, йа, йэ, йи, ва, вэ* эдгээр дөчин дөрвөн үсгийг зохиов. Хойно наймдугаар Хайсан хүлэг хаан Сажа Чойжи-Одсэр хэмээх ламыг залж, лам барьсанд лам тэр бээр *о, у, ө, ү, но, ну, нө, нү. бо, бу, бө, бү. хо, ху, хө, хү. го, гу, гө, гү. мо, му, мө, мү, ло, лу, лө, лү, ро, ру, рө, рү, со, су, сө, сү, до, ду, дө, дү, то, ту, тө, тү, жо, жу, жө, жү, чо, чу, чө, чү, йо, йу, йө, йү* эдгээр тавин зургаан үсгийг нэмж *Монголын нэгэн зуун үсэг* хэмээн нэрийдэн зохиогоод судар орчуулахуйд үсэг дутагдсанд фа, ша хоёр, залган бичихүйд жа (ꡊ) үсгийг за (ꡎ) үсэг мэт бичих ба язгуур дагаж долоодоор хувилгах хорин нэгэн үсгийн дээр -нг[6], -ийар хоёрыг нэмээд нэгэн зуун хорин гурван үсэг болгов хэмээн номложухуй. Үүнээс гадна олон богд мэргэдийн зохиосон монгол үсэг олон боловч манай Монголын бичиж, журам болсон хэдэн үсгийг товчлон гаргаваас “ла” (ꡁ), хөндий хэмээх “х” (ꡈ) хоёр үсгийг давхарлан бичвээс “лх” (ꡁꡈ) хэмээмүй, “ча” (ꡊ) үсгийн дээр хий зартиг татваас “за” (ꡊ) хэмээмүй, “ча” (ꡊ) үсгийн тэгш өнцөгт фуху тавиваас ца (ꡊ) хэмээмүй. Цөм урьд үсгүүд лүгээ адил тус бүр долоо хувилмуй. Ерөнхий Монголын үсэгт эр хэмээх чанга, эм хэмээх хөндий, эрс хэмээх саармаг гурван ялгал буй. Аль буй хэмээвээс *а о у, на но ну, ба бо бу, ха хо ху, га го гу, ма мо му, ла ло лу, ра ро ру, са со су, да до ду, та то ту, жа жо жу, ча чо чу, йа йо йу, фа фо фу, ша шо шу, за зо зу, лха лхо лху, за зо зу (ꡊ' ꡎ' ꡎ), ца цо цу (ꡊ' ꡎ' ꡎ), ва* энэ нь цөм эр үсэг болой. *э ө ү, нэ нө нү, бэ бө бү, хэ хө хү, гэ гө гү, мэ мө мү, лэ лө лү, рэ рө рү, сэ сө сү, дэ дө дү, тэ тө тү, жэ жө жү, чэ чө чү, зэ зө зү, фэ фө фү, шэ шө шү, цэ цө цү, лх лхө лхү, зэ зө зү (ꡊ' ꡎ' ꡎ), цэ цө цү (ꡊ' ꡎ' ꡎ), вэ,* энэ нь цөм эм үсэг болой. *и ни би хи ги ми ли ри си ди ти жи чи зи фи ши ци лхи зи (ꡊ) ци (ꡊ).* Энэ нь цөм саармаг үсэг болой. Үүний дотор дэвсгэр өгөх арван нэгэн үсэг буй аль буй

---

[1] Жавзансодномзэмо
[2] Годан
[3] Амдо
[4] Зүй нь бэлгэ тэмдгийн “бэлгэ” байх ёстойг эхэд андуу бичжээ.
[5] Бэлгэлэн, бэлгэ болгон бэлгэдэн гэсэн үг.
[6] Их инхлэг нь эгшиг дагуулж амь авахгүй тул толгой үсэгт оруулалгүй тусад нь нэмжээ.

хэмээвээс *на ба га ма ла ра са да йа уа нг* эдгээр болой. Дэвсгэрлэх ёсыг үлгэрлэн үзүүлбээс “на” нь дунд болбоос “хүнд”, адагт болбоос “хөнгөн” мэт бичээд өмнөх нэг дуслыг хасмуй. “ба” нь дунд болбоос “товч”, адагт болбоос “төлөв” мэт, “га” нь эр үсгийн дунд болбоос “суусан”, адагт болбоос “засаг” мэт бичээд, өмнөх хоёр дуслыг хасмуй. Эм ба саармаг үсгийн дунд болбоос “үзсэн”, адагт болбоос “бичиг” мэт бичмүй. “ма” нь дунд болбоос “амт”, адагт болбоос “эм” мэт бичмүй. “ла” нь дунд болбоос “алт”, адагт болбоос “гургуул” мэт бичмүй. “ра” нь дунд болбоос “урт”, адагт болбоос “охор” мэт бичмүй. “са” нь дунд болбоос “төгсгөн”, адагт болбоос эцэс мэт бичмүй. “да” нь дунд болбоос “хүндэтгэх”, адагт болбоос “эзэд” мэт бөгөөд “эд, дэд” мэт бичих нь бас буй амуй. “йа” нь дунд болбоос “сайхан” адагт болбоос “далай” мэт бичмүй. “уа” нь дунд болбоос “хууль”, адагт болбоос “эрүү” мэт бичмүй. “нг” нь дунд болбоос “тансаг”, адагт болбоос “жаргалан” мэт бичмүй. Бас “йа” дэвсгэрийн доор *на га да ма ла ра са* энэ долоон үсгийг дэвсэж давхар дэвсгэр хэмээдэг буй. Аль буй хэмээвээс *айин, айиг айид айим айил айир айис* энэ мэт болой. *Айнг айв* хэмээн бичиж болохоор номлосныг үзсэнгүй тул эс бичвэй. Эдгээр дэвсгэрийн үсгүүд цөм амьгүй тул амь залгадаг зургаан үсэг буй. Аль буй хэмээвээс *-а -и -у -уу -ун -ууд* эдгээр болой. Үлгэрлэвээс *тэгүн-э, баг-а, тэгүн-и, тан-у, сайн-уу, хад-ун, сайд-ууд* мэт болой. Үүнээс гадна үсгийн нөхцөл болж бусдын эрхэд дагалдан явах хорин үсэг буй. Аль буй хэмээвээс *-йи, -йин, -бар/ -бэр, -бан/ -бэн, -ийар/ -ийэр, -ийан/ -ийэн, -нугуд, -нүгүд, -луг-а, -лүгэ, -даган, -дэгэн, -таган, -тэгэн, -дур/ -дүр, -тур/ -түр, -чу/ -чү, -жу/ -жү, -ану, -инү* хорь болой. Эдгээр хорин үсэг болбоос урдах үсгийн эрхэд дагалдаж үг болох тул бусдын эрхт үсэг хэмээмүй. Үүнээс дээш амь залгадаг ба бусдын эрхэнд дагалдан явах хорин зургаан үсгийг ямар үсэгт амь залгах ба, ямар үсгийн эрхэд дагалдан бичихүйг тодорхойлбоос “-а” энэ нь арван нэгэн дэвсгэр үсэг бүгдийн доор бичмүй. *-йи, -йин, -бар/ -бэр, -бан/ -бэн* энэ дөрвийг *йа, ва* хоёр дэвсгэр ба дэвсгэргүй үсэг бүгдийн доор бичмүй. *–нугуд, –луг-а, -даган, -таган, -ану* энэ тавыг цөм эр үсгийн доор бичмүй. *–нүгүд, -лүгэ, -дэгэн, -тэгэн, -инү* энэ тавыг цөм эм ба эрс үсгийн доор бичмүй бас дахин ялгаваас *ба га ра са да* энэ таван дэвсгэрийн доор болбоос *-тур, -таган, -тэгэн* гурвыг бичээд дэвсгэр үсэгт залгаж бичих “-чу/ -чү”-г мөн энэхүүд бичмүй. *-дур -даган -дэгэн* дэвсгэр үсэгт залгаж бичих ч энэ дөрвийг мөн *ба га ра са да* таван дэвсгэрээс бусад зургаан дэвсгэр үсэг ба дэвсгэр үгүй үсэг бүгдийн доор бичмүй. “-уу” үүнийг *мөн үү бус уу* хэмээх зэрэг асуух үгсэд хэрэглэмүй. *а э и о у ө ү* энэ долоо монгол үсгийн анх нь мөний тул *ах үсэг* хэмээмүй. Бас бичгийн тэргүүнд бичихээс бус дунд ба адагт бичиж үл болох тул *эх үсэг* хэмээмүй. Үсэг бүрийг “а”-гийн эгшгээр дуудагдахын тул эгшиг үсэг хэмээмүй. “а” үсгээр амь эс орсон үсэг үгүй тул тийнхүү эгшиг үсэг хэмээн нэрийдсэн болой. Үлгэрлэвээс “на”-д *о у* амь орж *но ну* болох тэргүүтнийг өгүүлжүхүй бас эр эм хоёр үсгийг нэгэн үсэгт залган бичиж үл болмуй. Эрс үсгийг эр ба эм үсгийн алинд боловч залган бичиж болох тул саармаг үсэг хэмээн нэрийдсэн болой. Тийм боловч хүний нэрийг тасалдуулалгүй бичих ба бусад хэлээр үг

бичихүйд “а”-гийн төрлийн долоон үсэг дунд орох ба эр эм хоёр үсгийг хольцолдуулан бичсэн мэт боловч чухамдаа тийм бус мэт бөгөөд, учир юу хэмээвээс тус тусдаа нэгнээ холбох үгсийн эх болох тул ихлээ харшлах газар үгүй хэмээмүй. нө нү бө бү хө хү тэргүүтэн урт ацаг бүхий эм үсгүүдийг бичгийн дунд ба адагт болбоос урт ацгийг цөм хасаж бичмүй. Үлгэрлэвээс ᠬᠣᠨᠳᠣᠨ мэдүүлэх ᠬᠦᠷᠭᠦᠯᠬᠡ хүргүүлэх мэт болой. ᠬᠣᠨᠳᠣᠨ мэдүүлэх ᠬᠦᠷᠭᠦᠯᠬᠡ хүргүүлэх энэ мэт бичвээс асар зохис үгүй буй за. Бас монгол үг нэрийг үсэг болгон бичихүйд “га”-гийн аймгаар уртатгалын хувь оруулж тогтоосон бөгөөд үлгэрлэвээс хаалга хаах. Үүд нээх мэтээр бичихүйг жишиж мэдэгдэхүй. Бас аливаа олон нэрийн үсгийн дотор *барсын ав, тэрсийн багш, арслангийн омог* хэмээх үсгийн “ра са”-г залгалдуулан амь үгүй бичих ба найман хэмээх тооны үсгийн “йа” дэвсгэрийн урт ацаг хоёроос нэгийг бичих, *гүйцэд сүйтгэн* мэт үсгийг бичихэд “гү сү”-гийн нэгэн урт ацаг ба “йа” дэвсгэрийн хоёр урт ацаг байваас зохихоос хоёрыг бичих “тэнггэри” хэмээн хэлээд “тнгри” хэмээн бичих. Үзгийг үсэг, сүжгийг сүсэг, шажнийг шашин. Эр үгэн *хив хадаг, хир тоосон, нүх худаг, агшин зуур, оюу эрдэнэ* хэмээх үгсийг ийнхүү бичих ба бас *амуй за буй за*-г энэ мэт бичээд жа-ийн эгшгийг бардаагаар олгож дуудах эрх журам олон буй ану халж үл болох болой. Бас эрс үсгийн дунд орсон урт богино хоёр ацаг “йа” дэвсгэрийн дунд орсон урт хоёр ацгийг хоорондоо ялгавар үгүй сольцолдуулан бичиж үл болохыг хичээлтэй буй. Ер урьд урьдын хуучин хэвийн сударт *лүгэ нүгүд* хоёрын урт ацаг хассан ану болбоос Чин улсын олон богд хаадын үеийн тархаан гаргасан хууль толь зэрэг бичгийн дармалд *лүгэ* (ᠯᠦᠭᠡ) *нүгүд* (ᠨᠦᠭᠦᠳ) ийм бичсэн инү адилгүй боловч Хэлний чимэг хэмээх сударт *лүгэ нүгүд* хоёр дээдэх үсгийн сүүл мөний тул эмийн тэмдэг үл тавимуй хэмээсэн тулд урт ацаг үгүй бичвээс зохимуй. Бас үсгийн махбод хэмээбээс *а э о у нг* хийгээд *га ха* төрлөөр хамт арван есөн үсгийг дуудахуйд хоолойн орноос төрөхийн тул огторгуй махбодтой, *и* хийгээд *жа ча са за ца* төрлөөр хамт гучин зургаан үсэг хэлний үзүүр шүд тагнайнаас гарах тул хий махбодтой, *ра* төрлөөр долоон үсэг орой хөдөлгөж гарах тул гал махбодтой, *да та на ла са* төрлөөр гучин таван үсэг хэлний үзүүр шүднээс гарах тул шороо махбодтой, *ө ү ва вэ* хийгээд *ма ба фа* төрлөөр хамт хорин таван үсэг уруул хумбихын орноос гарах тул усан махбодтой хэмээсэн ба үсгийн махбодыг ялгаж таниулсны тус хэрэг инү юун буй хэмээбээс нэрийн тэргүүн үсэг хаан түшмэл мэт хийгээд ноён боол мэт ба лам шавь мэт хийгээд эр эм мэт ба эцэг хөвгүүн мэт хийгээд хатан шивэгчин мэтүүдийн нэрийн тэргүүн хоёр үсгийг нөхөр дайсныг тоолж түшмэл эх бөгөөд ноён хөвгүүн бөгөөс эрхэм сайн хийгээд түүнчлэн лам шавь ба эр эм дүрээр түүн лүгэ адал эцгийн нэрийн тэргүүн үсэг эх хийгээд хөвгүүний нэрийн тэргүүн үсэг хөвгүүн болбоос сайн болой. Түүнчлэн эх үгэнд бээр адил болой. Бас гэргийтэн хүн аль газарт буух буюу гэр барих болбоос тэр газрын нэрийн тэргүүн үсэг өөрийн нэрийн тэргүүн үсэг хоёрын нөхөр дайсныг тоолж номложухуй. Бас аливаа үсгийн залгалдуулан бичихүй дор *га ха* чангаар бичгийн дунд орвоос гурваад ацаг, *го гу хо ху* мөн дунд ба адагт орвоос хоёр ацагтай гэдэс, *та* дунд ба адагт болбоос *да*-гийн дүрээр бичих *да*-г өөрийн эрхэт

үсгийн тэргүүнд болбоос *та*-гийн дүрээр бичих тэргүүтэн хэлбэр янз урвах зүс олон боловч их төлөвийг судар бичгүүдээс үзээд мэдэж болох тул бүрнээ гаргасангүй. Гагцхүү дэвсгэрлэх ба холбох ёсыг өчүүхэн үзүүлэхүй дор бүгд үсгүүдэд дан дэвсгэр өгч үйлдэхүй инү: *ан нан бан хан, аг наг баг хаг, ав нав бав хав, ам нам бам хам, ал нал бал хал, ар нар бар хар, ас нас бас хас, ад над бад хад, ай най бай хай, ау нау бау хау, анг нанг банг ханг, эг нэг бэг хэг, иг ниг биг хиг.* Давхар дэвсгэрийг дээр гаргасны тулд эс бичвэй. Хоёр эр үсэг холбохуй нь: *ан-а наг-а баг-а хан-а, ах-а нах-а бах-а хах-а, аг-а наг-а баг-а хаг-а, аба наба баба хаба, ама нама бама хама, ал-а нал-а бал-а хал-а, ар-а нар-а бар-а хар-а, аса наса бас хаса, ада нада бада хада, ажа нажа бажа хажа, ача нача бача хача, аца наца баца хаца, ай-а най-а бай-а хай-а, ау-а нау-а бау-а хау-а* хоёр эм үсэг холбохуй ану: *эхэ нэхэ бэхэ хэхэ*. Эр саармаг хоёр үсэг холбохуй ану: *ани нани бани хани, аби наби баби хаби, ахи нахи бахи хахи, ами нами бами хами, али нали бали хали, ари нари бари хари, аси наси баси хаси, ади нади бади хади, ажи нажи бажи хажи, ачи начи бачи хачи.* Эм саармаг хоёр үсэг холбохуй ану: *эни нэни бэни хэни*. Саармаг хоёр үсэг холбохуй ану: *ихи нихи бихи хихи*. Үүнээр бусдыг жишиж мэдэгдэхүй. Жич бас эгшиг үсэг, гийгүүлэгч үсэг, тийн ялгагч үсэг, хураах үг, нөхцөл үг, заах үг, үлигдэлт үг, төгссөн үг хийгээд үсгийг хурааж нэр болох, нэрийг хурааж үг болох, үгээр утгыг өгүүлэх тэргүүтэн үгсийн ялгавар нарийн учир маш олон боловч дэлгэрүүлэн бичихүйд мунхаг оюунд багтааж чадсан үгүй бөгөөд Огторгуйн маани хэмээх сударт тодорхой номлосны тулд түүнээс үзэж мэдэгдэхүй хэмээн мэргэдийн суурина эрхшээсэн Алшаа–а монлам рабажамба Агваандандарын зохиосон Хэлний чимэг хэмээх номлолыг гол иш болгож, мөнхүү түүнд хааяа зарим нэгэн битүүлгийг ини бусад мэргэдийн илэрхий зохиолоос түүж бага сагаар нөхөж бүдүүвчлэн бичсэн үүний тус хэрэг инү номын үсгийг буруу унших ба буруу бичсэн хир хилэнц асар хүнд хэмээсэн учрыг сайтар мэдэж ёсчлон дагаж явбаас түүний тус эрдэм хязгаалшгүй тул үсгийг сургагч үнэн шударга оюун төгөлдөр мэргэдийн ачлалт номын явдалд ашид даган баясахын санаагаар өчүүхэн төдий буяны нөхцөл болгон хуйлруулж *анхан сурах хөвгүүдийн оюуны амыг нээх Тодорхой толь* хэмээсэн үүнийг их Юань улсын ёсыг тахиж мандуулсан Наран гэрэлт түмэн наст Богд хааны суурин дор эрхшээсэн дөрөвдүгээр он, монгол үсгийг анх зохиосон дөрөвдүгээр машид гарсны харагчин туулай жилээс хойш зургаан зуун далан он нөгчсөн арван тавдугаар машид гарсны модон бар жилийн сага сарын сайн өдрөө халх Монголын доорд бичээч нэгэн бээр бичвэй. Алдал унал болсон буй бөгөөс аливаа мэргэдэд наманчлан өчмүй. Анхан сурах хөвгүүдийн оюуныг ариун зарлигийн эрхэт лам Манзушир хийгээд Эсрүн эгшигт охин тэнгэр адистадлахуй болтугай.

Mongγol üsüg-ün ayimaγ. Angqan surqu köbegüd-ün oyun-u ama-yi negegekü Todurqai toli[7] kemegdekü orusibai

(1) Blam-a manǰuširi kiged egesigtü ökin tngri-tür bisiren sögüdčü mörgümüi. Mongγol üsüg-ün yosun kemebesü Yuwan ulus-un angqan-u qaγan Činggis boγda tere ber Saǰa-yin bančin Sodnamcimu kemekü blam-a-luγ-a nayiran ǰokičaǰu blam-a barin šasin-u eki oluγsan-u učir-tur. Tegün-ü dörbedüger üy-e-yin qaγan Günden. Amdau töbed-ün ǰegün qoyin-a oyir-a šar-a tal-a-yin Liyanǰu qotan-dur saγuqui-yin üyes-tür saǰa bandida Güngkaǰalcan kemekü blam-a-yi ǰalaǰu blam-a bariγsan-iyar. Blam-a tere ber Mongγol-čud-tur üsüg-ügei tula yambar dürim-tei üsüg bolγaqu-yi tügdem bariǰu qonuγad örlüge erte beleg sinǰilebesü nigen ekiner (2) kümün kedürig modun bariǰu ireged mörgügsen-iyer beleglen üsüg-ün dürim bolγaǰu a e i. na ne ni. ba be bi. qa ke ki. γa ge gi. ma me mi. la le li. ra re ri. sa se si. da de di. ta te ti. ǰa ǰe ǰi. ča če či. ya ye yi. wa we. Edeger döčin dörben üsüg-i ǰokiyabai. Qoyin-a naimaduγar Qayisang külüg qaγan. Saǰa Čoyiǰi Odser kemekü blam-a-yi ǰalaǰu blam-a bariγsan-dur blam-a tere ber. o u ö ü no nu nö nü. bo bu bö bü. qo qu kö kü. γo γu gö gü. mo mu mö mü. lo lu lö lü. ro ru rö rü. so su sö sü. do du (3) dö dü. to tu tö tü. ǰo ǰu ǰö ǰü. čoču čö čü. yo yu yö yü. Edeger tabin ǰirγuγan üsüg-i nemeǰü mongγol-un nigen ǰaγun üsüg kemen nereyiddün ǰokiyaγad sudur orčiγulqui-dur üsüg dutaγdaγsan-dur fa ša qoyar ǰalγan bičikü-dür ǰa üsüg-i ǰa metü bičikü ba. Iǰaγur daγaǰu doluγad-iyar qubilγaqu qorin nigen üsüg-ün deger-e ng iyer qoyar-i nemeged nigen ǰaγun qorin γurban üsüg bolγabai kemen nomlaǰuqui. Egün-eče γadan-a olan boγda merged-ün ǰokiyagsan Mongγol üsüg olan bolbaču. Man-u Mongγol-un bičiǰü ǰirum boluγsan kedün üsüg-i tobačilan γarγabasu. la köndei kemekü h qoyar üsüg-i (4) dabqurlan bičibesü lha kememüi. ǰa üsüg-ün deger-e kii ǰartaγ tatabasu za kememüi. ča üsüg-ün öončüg-tür fuqu talbibasu ca kememüi. Čöm urida üsüg-üd-lüge adali tusbüri doluγ-a qobilγamui yerüngki Mongγol-un üsüg-tür er-e kemekü čingγ-a, em-e kemekü köndei ersü kemekü saγarmag γurban ilγal bui. Ali bui kemebesü, a o u. na no nu. ba bo bu. qa qo qu. γa γo γu. ma mo mu. la lo lu. ra ro ru. sa so su. da do du. ta to tu. ǰa ǰo ǰu. ča čo ču. ya yo yu. fa fo fu. ša šo šu. ja jo ju. lha lho lhu. za zo zu. ca co cu. wa. Ene inü čöm er-e üsüg bolai. e ö ü. ne nö nü. be bö bü. (5) ke kö kü. ge gö gü. me mö mü. le lö lü. re rö rü. se sö sü. de dö dü. te tö tü. ǰe ǰö ǰü. če čö čü. ye yö yü. fe fö fü. še šö šü. je jö jü. lhe lhö lhü. ze zö zü. ce cö cü. we. Ene inü čöm em-e üsüg bolai. i ni bi ki gi mi li ri si di ti ǰi či yi fi ši ji lhi zi ci. Ene inü čöm saγarmaγ üsüg bolai. Egün-ü dotur debisker ögkü arban nigen üsüg bui ali bui kemebesü na ba γa ma la ra sa da ya ua ng edeger bolai. Debiskerlekü yosun-i üligerlen üǰegülbesü na anu dumda bolbaču "kündü", adaγ-tur bolbasu "könggen" (6) metü bičiged emüneki nige dusul-i qasumui. ba anu dumda bolbasu "tobči", adaγ-tur bolbasu "tölüb" metü. γa anu er-e üsüg-ün dumda bolbasu "saγuγsan", adaγ-tur bolbasu "ǰasaγ" metü bičiged. Emüneki qoyar dusul-i qasumui. Em-e ba saγarmaγ üsüg-ün dumda bolbasu "üǰegsen", adaγ-tur bolbasu "bičig" metü bičimüi. ma anu dumda bolbasu

[7] Уг эх дээрээ "tooli" хэмээн бичсэн буй.

“amta”, adaγ-tur bolbasu “em” metü bičimüi. la anu dumda bolbasu “alta”, adaγ-tur bolbasu “γurγul” metü bičimüi. ra anu dumda bolbasu “urtu”, adaγ-tur bolbasu “oqur” metü bičimüi. sa anu dumda bolbasu “tegüsken”, adaγ-tur bolbasu “ečüs” metü bičimüi. da anu dumda bolbasu “kündüdkekü”, adaγ-tur (7) bolbasu “eǰed” metü böged. “ed ted” metü bičikü inü basa bui amui. ya anu dunda bolbasu “sayiqan”, adaγ-tur bolbasu “dalai” metü bičimüi. ua anu dumda bolbasu “qauli”, adaγ-tur bolbasu “eregüü” metü bičimüi. ng anu dumda bolbasu “tangsuγ”, adaγ-tur bolbasu “ǰirγalang” metü bičimüi. Basa ya debisker-ün door-a na γa da ma la ra sa. Ene doluγan üsüg-i debisčü dabqur debisker kemedeg bui. Ali bui kemebesü ayin ayiγ ayid ayim ayil ayir ayis ene metü boloi. aying ayib kemen bičiǰü bolqu-bar nomlaγsan-i üǰegsen-ügei tula ese bičibei. Edeger debisker-ün üsüg-üd čöm ami-ügei tula ami ǰalγadaγ (8) ǰirγuγan üsüg bui. Ali bui kemebesü. a i u uu un ud edeger bolai. Üligerlebesü “tegün-e baγ-a tegün-i tan-u sayin-uu qad-un sayid-ud” metü bolai egün-eče γadan-a üsüg-ün nöküčel bolǰu busud-un erke-dür daγaldun yabuqu qorin üsüg bui. Ali bui kemebesü yi yin bar /ber/ ban /ben/ iyar /iyer/ iyan /iyen/ nuγud nügüd luγ-a lüge daγan degen taγan tegen dur /dür/ tur /tür/ ču /čü/ ǰu /ǰü/ anu inü qori bolai. Edeger qorin üsüg bolbasu uridaki nüsüg-ün erke-dür daγalduǰu üge bolqu tula busud-un erketü üsüg kememüi. Egün-eče degegsi ami ǰalγadaγ ba. Busud-un erke-dür daγaldun yabuqu qorin ǰirγuγan üsüg-i yambar üsüg-tür ami ǰalγaqu ba, yambar üsüg-ün erke-dür daγaldun bičikü-yi (9) todurqayilabasu a ene inü arban nigen debisker üsüg bügüde-yin door-a bičimüi, üligerlen üǰegülbesü “baγan-a baγ-a em-e el-e er-e ay-a γou-a ab-a tegüs-e adistad-a ǰirγalang-a” metü bolai. i iyar iyan ene γurba-yi ya wa qoyar debisker-eče busud yisün debisker üsüg bügüde-yin door-a bičimüi. ud un ene qoyar-i na ya wa γurban debisker-eče busud naiman debisker üsüg bügüde-yin door-a bičimüi. u egün-i γaγča na debisker-ün door-a bičimüi. yi yin bar ban ene dörbe-yi ya wa qoyar debisker ba, debisker-ügei üsüg bügüde-yin door-a bičimüi. nuγud lug-a daγan taγan anu ene tabu-yi čöm er-e üsüg-ün door-a bičimüi. (10) nügüd lüge degen tegen inü ene tabu-yi čöm em-e ba ersü üsüg-ün door-a bičimüi. Basa dakin ilγabasu ba γa ra sa da ene tabun debisker-ün door-a bolbasu tur taγan tegen γurba-yi bičiged debisker üsüg-tür ǰalγaǰu bičikü ču-yi mön egün-dür bičimüi. dur daγan degen debisker üsüg-tür ǰalγaǰu bičikü ǰu ene dörbe-yi mön ba γa ra sa da tabun debisker-eče busud ǰirγuγan debisker üsüg ba. Debisker-ügei üsüg bügüde-yin door-a bičimüi uu egün-i mön-üü, busu-uu kemekü ǰerge asaγaqu üges-tür kereglemüi a e i o u ö ü ene doluγ-a mongγol üsüg-ün angq-a anu mön-ü tula aq-a üsüg kememüi. Basa bičig-ün (11) terigün-dür bičikü-eče busu dumda ba, adaγ-tur bičiǰü ülü bolqu tula eki üsüg kememüi. Üsüg büri-yi a-yin egesig-iyer daγudaγdaqu-yin tula egesig üsüg kememüi. a üsüg-iyer ami ese oruγsan üsüg-ügei tula teyin-kü egesig üsüg kemen nereyiddügsen bolai. Üligerlebesü na-dur o, u ami oruǰu no nu bolqu terigüten-i ögüleǰükü. Basa er-e em-e qoyar üsüg-i nigen üges-tür ǰalγan bičiǰü ülü bolumui. Ersü üsüg-i er-e ba em-e üsüg-ün alin-dur bolbaču ǰalγan bičiǰü bolqu tula saγarmaγ üsüg kemen nereyiddügsen bolai. Teyimü bolbaču kümün-ü ner-e-yi tasuldaγulal-ügei bičikü ba. Busud kele-ber üge bičikü (12) -dür a-yin törul-ün doluγan üsüg dumda oruqu ba er-e em-e qoyar üsüg-i qoličalduγulun bičigsen metü

bolbaču, čuqum-daγan teyimü busu metü bögüd, učar yaγu kemebesü, tus tus-taγan nigen-e qolbuqu üges-ün eki bolqu tula yekel-e qarsilaqu γaǰar-ügei kememüi. nö nü bö bü kö/gö/ kü /gü/ terigüten urtu ačuγ büküi em-e üsüg-üd-i bičig-ün dumda ba adaγ-tur bolbasu urtu ačuγ-i čöm qasuǰu bičimüi. Üligerlebesü medegülkü kürgegülkü metü bolai. MedegÜlkü kürgegÜlkü ene metü bičibesü asuru ǰokis-ügei bui-y-a. Basa mongγol üge ner-e-yi üsüg bolγan bičiküi-dür γa-yin ayimaγ-iyar urtudqal-un qubi olγuǰu (13) toγtaγaγsan bögüd üligerlebesü "qaγalγ-a qaγaqu", "egüde negegikü" metüber bičiküi-yi ǰisiǰü medegdeküi. Basa aliba olan ner-e-yin üsüg-ün dotur-a bars-un ab, ters-ün baγsi, arslan-u omuγ kemekü üsüg-ün ra sa-yi ǰalγalduγulun ami-ügüi bičikü ba. Naiman kemekü toγan-u üsüg-ün ya debisker-ün urtu ačuγ qoyar-ača nige-yi bičikü. Güičed süidken metü üsüg-i bičiküi-dür gü /kü/ sü-yin nigen urtu ačuγ ba ya debisker-ün qoyar urtu ačuγ bayibasu ǰokiqu-ača qoyar-i bičikü tenggeri kemen keleged tngri kemen bičikü. Üǰüg-i üsüg, süǰüg-i süsüg, šaǰin-i šasin. Er-e ügen kkib qadaγ kkir toγusun nüke quddug, gsin ǰaγur-a. Ogyu (14) erdeni kemekü ügis[8]-i eyin-kü bičikü ba. Basa amui-y-a, bui-y-a-yi ene metü bičiged ǰa-yin egesig-i bartaγabar olγuǰu daγudaqu erke ǰirum olan bui anu qalaǰu ülü bolqu bolai. Basa ersü üsüg-ün dumda or[u]γsan urtu boγuni qoyar ačuγ ya debisker-ün dumda oruγsan urtu qoyar ačuγ-i qoγurundu-ban ilγaburi-ügei soličalduγulun bičiǰü ülü bolqu-yi kičiyeltei bui. Yerü uridu uridu-yin qaγučin keb-ün sudur-tur lüge nügüd qoyar-un urtu ačuγ-i qasuγsan anu bolbasu Čing ulus-un olan boγda qaγad-un üy-e-yin tarqaγan γarγaγsan qauli toli ǰerge bičig-ün darumal-dur lüge nügüd eyimü bičigsen inü adali-ügei bolbačü "Kelen-ü (15) čimeg" kemekü sudur-tur lüge nügüd qoyar degedüki üsüg-ün segül mön-ü tula em-e-yin temdeg ülü talbimui kemegsen tulada urtu ačuγ-ügei bičibesü ǰokimui. Basa üsüg-ün maqabod kemebesü a e o u. ng kiged γa qa törül-iyer qamdu arban yisün üsüg-i daγudaqui. dur qoγulai-yin orun-ača törükü-yin tula oγtarγui maqabod-tai, i kiged ǰa ča sa ja ca, törül-iyer qamtu γučin ǰirγuγan üsüg kelen-ü üǰegür, sidü tanglai-ača γarqu tula ki maqabod-tai, ra törül-iyer doluγan üsüg orui ködüleǰü γarqu tula γal maqabod-tai, da ta na la sa törül-iyer γučin tabun üsüg kelen-ü üǰegür, sidün-eče γarqu tula sirui maqabod-tai, ö ü wa we kiged ma ba (16) fa törül-iyer qamtu qorin tabun üsüg uruγul qumbiqu-yin orun-ača γarqu tula usun maqabod-tai kemegsen ba üsüg-ün maqabod-i ilγaǰu taniγulγsan-u tusa kereg inü yaγun bui kemebesü ner-e-yin terigün üsüg "qaγan tüsimel" metü kiged "noyan boγul" metü ba. "Blam-a šabi" metü kiged "er-e em-e" metü ba "ečige köbegün" metü kiged "qatun sibegčin" metü nügüd-ün ner-e-yin terigün qoyar üsüg-i nökür dayisun-i toγalaǰu "tüsimel eke" böged "noyan köbegün" bögesü "erkim sayin" kiged tegünčilen "blam-a šabi" ba "er-e em-e"-dür-ber tegünlüge adali ečige-yin ner-e-yin terigün üsüg "eke" kiged köbegün-ü ner-e-yin terigün üsüg "köbegün" bolbasu sayin bolai. Tegünčilen eke (17) ügen-dür-ber adali bolai. Basa gergei-ten kümün ali γaǰar-tur baγuqu buyu ger bariqu bolbasu, tere γaǰar-un ner-e-yin terigün üsüg öber-ün ner-e-yin terigün üsüg qoyar-un nökür dayisun-i toγalaǰu nomlaǰuqui. Basa aliba üsüg-i ǰalaγalduγulun bičiküi-dür γa qa čingγ-a-bar bičig-ün dumda orubasu γurbaγad ačuγ γo γu qo qu mön dumda ba adaγ-tur orubasu qoyar ačuγ-

[8] üges

tai gedesü ta dumda ba adaγ-tur bolbasu da-yin düri-ber bičikü da-yi öber-ün erketü üsüg-ün terigün-dür bolbasu ta-yin düri-ber bičikü terigüten kelberi yangǰu urbaqu yosu olan bolbaču yeke tölüb-i sudur bičig-nügüd-eče üǰeged medeǰü bolqu tula. Bürin-e γarγaγsan (18)-ügei. γaγčakü debiskerlekü ba. Qolbuqu yosu-yi öčüken üǰegülküi-dür bügede üsüg-üd-tür dang debisker ögečü üiledküi inü. an nan ban qan. aγ naγ baγ qaγ. ab nab bab qab. am nam bam qam. al nal bal qal. ar nar bar qar. as nas bas qas. ad nad bad qad. ai nai bai qai. au nau bau qau. ang nang bang qang. eg neg beg keg. iγ nig biγ kig. Dabqur debisker-i deger-e γarγaγsan-u tulada ese bičibei. Qoyar er-e üsüg qolbuqui anu an-a nan-a ban-a qan-a. aq-a naq-a baq-a qaq-a. aγ-a naγ-a baγ-a qaγ-a. aba naba baba qaba. ama nama bama qama. al-a nal-a bal-a qal-a. ar-a nar-a bar-a qar-a. (19) asa nasa basa qasa. ada nada bada qada. aǰa naǰa baǰa qaǰa. ača nača bača qača ay-a nay-a bay-a qay-a. au-a nau-a bau-a qau-a. Qoyar em-e üsüg qolbuqui anu. Eke /ege/ neke /nege/ beke /bege/ keke /kege/. Er-e saγarmaγ qoyar üsüg qolbuqui anu. ani nani bani qani. abi nabi babi qabi. aki naki baki qaki. ami nami bami qami. ali nali bali qali. ari nari bari qari. asi nasi basi qasi. adi nadi badi qadi. aǰi naǰi baǰi qaǰi. ači nači bači qači. Em-e saγarmaγ qoyar üsüg qolbuqui anu. eni neni beni keni. Saγarmaγ qoyar üsüg qolbuqui anu. iki /igi/ niki /nigi/ biki /bigi/ kiki /kigi/. Egün-iyer busud-i ǰisiǰü medegdeküi. ǰiči basa egesig (20) üsüg giyigülügeči üsüg. Teyin ilγaγči üsüg, quriyaqu üge, nöküčel üge, ǰiγaqu üge, üligdel-tü üge, tegüsügsen üge, kiged üsüg-i quriyaǰu ner-e bolqu, ner-e-yi quriyaǰu üge bolqu, üge-ber udq-a-yi ögülekü terigüten üges-ün ilγaburi narin učar masi olan bolbaču delgeregülün bičiküi-dür mungqaγ oyun-dur baγdaγaǰu čidaγsan-ügei böged "Oγtarqui-yin mañi" kemekü sudur-tur todurqai nomlaγsan-u tulada tegünče üǰeǰü medegdeküi kemen merged-ün saγurin-a erkesiyegsen Alaša-yin monglam rabaǰamba Aγwangdandar-un ǰokiyaγsan "Kelen-ü čimeg" kemekü nomlal-i γool esi bolγaǰu, mön-kü tegün-dür qay-a ǰarim nigen bitegülig-i inü busud merged (21)-ün ilerkei ǰokiyal-ača tegüǰü baγ-a saγ-a-bar nöküǰü büdügübečilen bičigsen egün-ü tusa kereg inü nom-un üsüg-i buruγu ungsiqu ba buruγu bičigsen-ü kker kilenče asuru kündü kemegsen učar-i sayitur medeǰü yosučilan daγaǰu yabubasu tegün-ü tusa erdem kiǰaγalasi-ügei tula üsüg-i suryγči ünen sudurγu oyun tegüldür merged-ün ačilaltu nom-un yabudal-dur asida-taγan bayasqu-yin sanaγ-a-bar öčüken tedüi buyan-u nöküčel bolγan quyilarγulǰu "Angqan surqu köbegüd-ün oyun-u ama-yi negegekü todurqai toli" kemegsen egün-i Yeke Yuwan ulus-un yosun-i takiǰu manduγuluγsan Naran gereltü tümen nasutu Boγda qaγan-u saγurin-dur erkesiyegsen dörbedüger on, (22) mongγol üsüg-i angq-a ǰokiyaγsan dörbedüger masida γaruγsan-u qaraγčin taulai ǰil-eče qoyisi ǰirγuγan ǰaγun dalan on nögečigsen arban tabuduγar masida γaruγsan-u modun bars ǰil-ün saka sar-a-yin sayin edür-e Qalq-a mongγol-un dooradu bičigeči nigen ber bičibei. Aldal unal boluγsan bui bögesü aliba merged-tür nemegečilen [namangčilan] öčimüi. Angqara [angqan] surqu köbegüd-ün oyun-i ariγun ǰarliγ-un erketü blam-a manǰusiri kiged asrun egesigtü ökin tngri adistedleküi boltuγai.



МОНГОЛ ҮСГИЙН АЙМАГ. АНХАН СУРАХ ХӨВГҮҮДИЙН ОЮУНЫ АМЫГ НЭЭХ ТОДОРХОЙ ТОЛЬ ХЭМЭЭГДЭХ ОРШИВ